

БОЛОВСРОЛЫН СОЦИОЛОГИЙН ИНСТИТУЦЛЭЛ

Я.Отгонбаяр доктор, дэд проф

Orcid: 0000-0001-7297-2288

С.Нарантуяа доктор, дэд проф

Orcid: 0000-0003-1736-4313

МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим

Abstract: *The article aims to show the institutionalization, theoretical and methodological changes and development of educational sociology, which is one of the main branches of sociology, while also discussing the development of educational sociology in Mongolia, the research done, and the need for further development. The changes in educational sociology research theory, methodology, and research are explained in connection with the demands of social development.*

Key words: *sociology of education, theory, research, benefit of education.*

1. Боловсролын социологийн хөгжлийн үйл явц

Боловсролын социологи нь боловсролыг нийгмийн харилцаатай нь холбож судалдаг бөгөөд сүүлийн 70-аад жил харьцангуй эрчимтэй хөгжиж байгаагаас гадна дотооддоо ялгарлыг бий болгож дээд боловсролын социологи, заах арга зүйн социологи, бага сургуулийн социологи гэх зэрэг салбаруудыг үүсгэн хөгжүүлсээр иржээ. Дээд боловсролын социологийг үндэслэгч (Burton R. Clark, 1973) дээд боловсролын социологи нь үүссэнээс хойш гуч гаруй жил болж байгаа хэдий ч өрнөдийн орнуудад эрчимтэй хөгжсөөр байна гээд тэрээр 1970-аад оны эхээр социологийн онол, арга зүйгээр их, дээд сургуулиудад тулгамдаад байгаа асуудлуудыг ойлгоход дээд боловсролын социологийн хувь нэмэр чухал гэж үзсэн. 1970-аад оноос Дэлхийн Социологийн Холбооноос боловсролын социологийн хөгжилд албан ёсоор анхаарлаа хандуулж эхэлсэн бөгөөд 1978 оны 8-р сарын 14-20 нд Шведэд зохион байгуулагдсан

Дэлхийн Социологийн Холбооны 9-р их хурал дээр боловсролын социологийн хөгжлийн асуудлыг онцлон авч үзжээ. Энэ бүхэн нь боловсрол өөрөө нийгмийн хүчирхэг хэрэгсэл, өөрчлөлт шинэчлэлтийн, хөгжлийн хамгийн чухал хүчин зүйл, нийгмийн бусад олон асуудалтай ямагт холбоотой байдгийг социологийн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрсний тод илрэл юм.

Социологичид боловсролын асуудлыг XIX зууны сүүлч XX зууны эхнээс тусгайлан судлах болсон. Боловсролын түүхэнд XIX-XX зууны үеийн Францын шинжлэх ухааны сургууль, ялангуяа Г.Компейре, Э.Дюркхайм нарын бүтээл их нөлөөлсөн. Энэ нь хөдөлмөрийн хуваарийн нарийн зохион байгуулалт мөн нийгмийн давхраажилт зэрэг нийгмийн тодорхой асуудлуудтай холбогдон гарч ирсэн. Анх боловсролын асуудлыг социологид дэвшүүлэн тавьсан хүмүүс нь Э.Дюркхайм, Ж.Дью нар юм. Барууны аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад боловсролын асуудал 60, 70 аад оноос хүчтэй тавигдах болсон нь дараах шалтгаантай.

Үүнд:

1. Шинжлэх ухаан техникийн хөгжлөөс “боловсрол” өөрөө хоцорч ирсэн.
2. Ажилгүйдэл, гэмт хэрэг, биеэ үнэлэх, хар тамхи зэрэг нийгмийн эмзэг асуудал нь боловсролтой холбогдох болсон.
3. Энэ үед боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн төлөө оюутан залуус өргөн олны хөдөлгөөн хүчтэй өрнөж байсан.

Боловсрол судлаач Ф.Кубс боловсролын хямралын нөхцөл байдал нь боловсролыг арга буюу судлахад хүргэсэн гэж үздэг (Сарантуяа О, 2005).

Тухайлбал, боловсролын хүртээмжийн асуудал, оюутан залуусын амьдралын хэв маяг оюутан багшийн харилцаа, харилцан нөлөөлөл, мэргэжил сонголт, мэргэжлийн престиж, боловсролын нэр хүнд, түүнийг нийгмээс үнэлэх үнэлэмж, багшийн мэргэжлийн сонголт, хүлээлт, нийгэмд эзлэх байр суурь зэрэг олон асуудлаар судалгаа хийх зайлшгүй шаардлагатай болсон. Социологийн сонгодог төлөөлөгчид болох Дюркхайм Э, (1858-1916) боловсролын нийгмийн хэв журмыг хадгалахад оруулж буй хувь нэмэр, Маркс.К (1818-1883) нийгмийн шинэ систем тогтоох нөхцлийг бүрдүүлэгч хүчин зүйл, Мангейм.К (1887-1947) нийгмийн дотоод зөрчлийг арилгах, аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэл, Парсонс.Т (1902-1979) нийгмийн тогтвортой байдлыг хангагч институт гэж тус тус судалж ирсэн.

Боловсролын социологи нь социологийн онолын болон тодорхой судалгааны аргаар боловсролын үйл явц, боловсролын социаль харилцааг судалдаг төдийгүй бусад салбар социологиос судалгааны объект зорилго чиглэлээр ялгагдах онцлогтой бөгөөд нийгэм, соёлын хөгжил, үнэлэмж, үнэт зүйлсийн төлөвшилд боловсролын гүйцэтгэх үүрэг, уламжлал шинэчлэл зэрэг өргөн хүрээтэй асуудлыг онолын хүрээнд судлахын зэрэгцээ мөн тодорхой хүрээнд ч эмпирик судалгаагаар задлан шинжилдэг.

Сургалтын үйл явц, түүний хэлбэр агуулга, бүх шатны сургуулийн бүтэц, зохион байгуулалтаас эхлээд суралцагчдын сонирхол, багш нарын мэдлэг чадвар, бэлтгэн гаргаж буй боловсон хүчний чанар, орчин үеийн нийгэм дэх боловсролын хэрэгцээ шаардлага зэрэг асуудлууд ч боловсролын социологийн судлагдахуун болдог. Боловсролын социологи нь боловсролыг хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг нөхцөлдүүлж байдаг бие даасан социаль институт гэж үздэг (Майер А.А., 2012).

Патрика. Ж (2007) О.Конт социологи нь нийгмийн дэг журам, тогтвортой байдал, өөрчлөлт, эсвэл нийгэм, түүний систем, байгууллагын хөгжил дэвшлийг судалдаг гээд тэрээр нийгмийн байгууллагууд өөр хоорондоо байнгын харилцан үйлдэлд орж байдаг ба жишээ нь боловсрол эдийн засаг, улс төр, соёл, хууль эрх зүйн гэх мэтээр тайлбарлажээ хэмээн өөрийн бүтээлдээ дурьджээ. Америкийн социологич Изью (1990) сургалтын орчноос олж авдаг зан үйл нь ихэвчлэн нийгмийн шинжийг илэрхийлсэн байдаг ба энэ нь хувь хүний болон нийгмийн хооронд маш ойрхон харилцаа, харилцан үйлдэл явагдаж байдаг гэдгийг харуулж байна гэж үзсэн. Петр Шельсон (1974) хүний эсэн мэнд амьдрах, нэг үеийнхний бий болгосон мэдлэг, туршлагыг дамжуулж, дараагийн үеийг бэлтгэх нөхцлийг боловсрол олгодог. Өнөөдөр хүн төрөлхтөн шинэ ур чадвар эзэмших хэрэгцээтэй болж байгаа төдийгүй шинэ нийгмийг байгуулах нь бидний өмнө тулгарч байгаа гол асуудал бөгөөд шинэ соёлыг залуучуудад зааж, мэдлэг нь нэг үеэс дараагийн үед дамждаг. Энэ нь боловсрол нь тасралтгүй үйл явц юм гэдгийг бидэнд ойлгуулдаг. Петр Харольд (1968) боловсролын социологийн агуулгыг тэрээр хувь хүн, нийгмийн институтын хооронд боловсролоор дамжин үүсэх харилцааны түүхэн хэв маягийг судлахад чиглэх ёстой гэж үзсэн бөгөөд түүний энэ тодорхойлолт нь боловсролын социологийн судалгаанд түүхэн арга барилыг ашиглах гэсэн арга зүй бөгөөд энэ нь нийгмийн байгууллагуудын хоорондын харилцаа, хөгжлийг хангах гол механизм юм.

Боловсролын социологийн үндэслэгч хэмээн зүй ёсоор үнэлэгддэг Э.Дюркхайм (1858-1917) нь боловсролыг нийгмийн систем, эмх журмын талаас нь судалсан.

Нийгмийн дэвшлийг хангахад боловсролын гүйцэтгэх үүргийг хүн төрөлхтний иргэншил соёлын хөгжил улам бүр тодруулсаар байна. Боловсрол нь соёлын төрөл бүрийн хэлбэрийг эзэмшихээс эхлээд хөдөлмөрийн тодорхой үйлдлийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд шууд холбогдох бөгөөд энэ нь бие хүний боловсрол эзэмших явдал зайлшгүй шинжтэй болохыг үндэслэдэг юм.

Социологичид 1970-аад оноос боловсролд анхаарлаа хандуулах нь илүү эрчимжсэн. Тухайлбал илүү өргөн хүрээгээр буюу нийгмийн систем, улс төрийн бодлоготой холбож судлах болсон.

Боловсролын социологид функционализм символик интеракционизм, зөрчилдөөний онол гэсэн гурван онол зонхилж ирсэн бөгөөд эдгээр нь тус бүрийн арга зүйгээр боловсролын харилцааг тайлбарласан. Үүний дотроос функционализм боловсролыг нийгмийн систем, институт болохынх нь хувьд авч үзсэн гол онол юм.

Функционалистууд боловсрол нь нийгмийн хяналтын хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд гэр бүл, шашин, хуулийн тогтолцооны нэг адил нийгмийн тогтвортой байдлыг тэтгэн дэмжихэд чиглэсэн институт гэж үзнэ. 1960-аад он хүртэл боловсролын социологид функционализм голлох байр суурьтай байсан хэдий ч зарим социологичид зөрчилдөөний үүднээс боловсролын харилцааг тайлбарлаж байсан. Зөрчилдөөний онолын үүднээс Р.Дарендорф, Л.Козер нар боловсролын агуулгаас шалтгаалан бүлгүүдийн хооронд үүсэх зөрчлөөр хязгаарлагдаагүй бөгөөд боловсрол өөрөө бүлгүүд хоорондын зөрчилдөөний биелэл байж болно гэж үзсэн байна. Боловсролын агуулгыг тодорхойлоход ямагт зөрчил үүсдэг. Энэ зөрчил нь улс төрийн шинжтэй байж болно. Хэн эрх мэдэлтэй байна тэр хүн өөрийнхөө үнэт зүйлийг боловсролын системрүү голлох байр суурь эзлүүлэхийг эрмэлздэг. Мөн аль нэг шашин өөрийнхөө үзэл номлолыг сургалтад янз бүрийн агуулгаар оруулахыг хичээж байдаг учраас ер нь боловсролын агуулгаас хамаарч нийгмийн бүлгүүдийн хооронд зөрчил үүсдэг гэдгийг онцлон анхаарсан (Bidwell Charles E , 1988)

. Энэ нь нийгмийн бүлгүүд өөр өөр сонирхолтой байдгаас зарим нь боловсролоос маш их ашиг тусыг хүлээж байдагтай холбоотой.

Боловсролыг авч үзэх функционализм ба зөрчилдөөний онолын зарим ялгааг харуулбал:

Хүснэгт 1

| Функционализм | Зөрчилдөөний онол |
|--|--|
| Боловсрол нь хувь хүмүүст өөрийгөө хөгжүүлэх боломж олгодог. | Тулгуурлаж байгаа үнэт зүйл, харьяалагдаж байгаа нийгмийн бүлгээс хамаарч нийгэмшил нь янз бүр байдаг учраас боловсрол нь хүмүүсийн хооронд зөрчил үүсгэдэг гэж үздэг. |
| Нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл гэж үздэг. | Боловсролын үүрэг бол нийгмийн тэгш бус байдлыг хадгалахад чиглэх ёстой гэж үздэг. |

1970 аад оноос боловсролын социологийн хөгжилд шинэ үе ирсэн. Тухайлбал боловсролын гол утга учир юунд орших вэ, боловсролтой гэдэгт юуг ойлгох вэ зэрэг асуултын хариуг хайж эхэлсэн. Сургууль, анги танхим, сургалтын хөтөлбөр, багшийн мэргэжлийн ур чадвар, нийгмийн статус, нэр хүнд зэрэг асуудлууд боловсролын социологийн тодорхой судалгааны объект болсон. Цаашид боловсролын асуудалд Америкийн социологич А.Гидденс (1975) анхаарлаа хандуулсан. Тэрээр сургуулийн гол үүрэг бол хүмүүсийг гэгээрүүлэх явдал гэж үзэж мэдлэгийн хэрэглэгдэх шинжийг голлож анхаарах хэрэгтэйг санал болгосон.

1960-аад оны үед боловсролын социологийн үндсэн фокус нь боловсролыг нийгмийн байр суурь эзлэх гол хүчин зүйл гэж үзэж байсан бол 1970-аад оноос боловсролыг илүү өргөн хүрээтэй буюу багш суралцагч, сурлагын амжилт, боловсролын байгууллагыг соёлыг бүтээгч болохынх нь хувьд, суралцагчдын хүйсийн харьцааны асуудал, багшийн сургалтын үйл, хэв маягт тодорхой судалгаа хийж үнэлэлт өгөх түвшинд хүрсэн.

XX зууны 70-аад он буюу хүмүүс дээд боловсролд урьд өмнөх үеэсээ илүү ач холбогдол өгөх болсон энэ үетэй постмодернизм салшгүй холбоотой. Постмодернист З.Бауманы үзлээр модернистууд уламжлалт боловсролын тогтолцоог шүүмжилдэг, нийгэм соёлын шинэ чиглэлийг бий болгохыг

эрмэлзсэн боловч одоо бид тэр шинэ үе гэдгийг аль хэдийн өнгөрөөсөн тул түүнээс шинэ үе ирж байна гэж үзсэн. Орчин үед боловсролын социологид конструктивист онол, мэдээллийн технологийн ололт эрчимтэй нэвтрэн орж байна. Боловсролын социологи дахь модернист парадигмын гол онцлог нь үр ашигтай мэдлэг, түүний зохистой үнэлгээ, боловсролын байгууллагын тогтвортой бүтэц, их, дээд болон түүний дараах сургалтын тогтолцооны маш сайн төлөвлөгөө, туршлага, эдгээрийг зохицуулах эрх зүйн орчинг бий болгохыг эрмэлзэж ирсэн (Arum Richard, 2000)

1970 аад оноос боловсролын судалгаанд түүний нийгмийн болон хувь хүнд өгөх үр ашгийн талаар судалгаанууд эрчимтэй хийгдсэн. Нийгэмд хувь хүн бүр капитал. Эндээс хүний мэдлэгээр дамжуулан нийгэмд баялаг бүтээгдэнэ гэсэн харилцаа хамаарлыг харуулсан.

Боловсролын үр ашиг гэдэг (benefit) нь боловсролоос хувь хүний болон нийгмийн хүртэх давуу талууд. Боловсрол эзэмшсэн хүн өөрийн боловсролоос үр ашиг хүртэхээс гадна түүний эргэн тойронд байгаа хүмүүс, нийгэм түүний боловсролоос үр ашиг хүртдэг. Боловсрол нь эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлөхөөс гадна ажилгүйдэл, ядуурал, гэмт хэргийг бууруулах, нийгмийн эв нэгдлийг хангах зэргээр нийгмийн амьдралд олон талаар ач холбогдолтой. Боловсролын эдийн засгийн үр ашгийг хэт сурталчилснаар нийгмийн үр ашгийг орхигдуулж нийгмийг хэт “материаллаг” болгоход түлхэж байна хэмээн нийгэм судлаачид, тухайлбал Behrman (1997) эдийн засагчдыг буруутгадаг.

Боловсрол хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэх замаар үр ашгаа өгдөг гэж Behrman, Crawford, Stacey нар 1997 онд “Benefit of education” номондоо бичжээ. Боловсролын социологи дахь постмодернизм нь соёл, мэдээллийн хүртээмжийн нээлттэй байдлыг улам нэмэгдүүлснээр нийгмийн эв нэгдэл, тогтвортой байдлыг хангагч, боловсролтой дунд ангийг бий болгох нь боловсролын социологийн орчин үеийн тулгамдсан асуудал гэж тодорхойлсон. Боловсролын социологийн постмодерн чиглэлийг баримтлагсад тухайлбал Barro (1999), Glaezer, Ponzetto, Almond, Verba.,(1989), Robinzon.,(2004) нарын хийсэн эмпирик судалгаа нь боловсрол нь нийгмийн соёлыг хөгжүүлж, ардчиллыг бэхжүүлж, иргэний оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг дэмжихэд чухал үүрэгтэйг нотлон харуулсан. Тодруулбал: Алмонд Верба (Almond Verba 1989) боловсрол ардчилалыг бэхжүүлэхэд хамгийн чухал хүчин зүйлийн нэг юм. Барро (Barro 1999) дээд боловсрол ардчилсан улс төрийг бэхжүүлэхэд нөлөөлнө. Сен (Sen 1999) боловсрол нь нийгмийн эв нэгдлийг хангадаг. Хэлливел Путнам (Hellivel Putnam 1999) боловсролтой хүмүүс амархан нийгэмшдэг. Мак Мэхон (Mac Mehon 1999) бүрэн дунд боловсрол эзэмших нь нийгмийн тогтвортой байдалд нөлөөлдөг. Жонсон Робинсон (Jonson Robinson 2004) боловсрол нь нийгмийн сайн сайхан байдлыг урт хугацаанд хадгалдаг. Милиган Морети (Milligan Moretti 2004) боловсрол иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлдэг. Ийнхүү боловсролыг авч үзэх, түүнийг ойлгох ойлголт түүхэн цаг хугацаа, нийгмийн хөгжлөө даган хувьсан өөрчлөгдөж иржээ.

Боловсролын социологи нь өөрийн гэсэн түүх, шинжлэх ухааны зарчим, арга зүй, судлах зүйлтэй болж хөгжил нь институтчлагдах үйл явц Э.Дюркхайм, Дж.Дью нарын нэртэй салшгүй холбоотой. Боловсролын социологи нь бие даасан курс болж 1910 онд 40, 1926 он гэхэд 194 коллежид уншигдаж, 1916-1936 оны хооронд боловсролын социологийн чиглэлээр 25 сурах бичиг гарсан. 1940-өөд он буюу дэлхийн 2 дайны үеэр шинжлэх ухаанууд бага зэрэг уналтанд орсон. 1960 аад оноос өрнөдөд академик газруудад боловсролын социологийг дахин заах болсон. 1965 онд Америкт анхны “Sociology of education” гэсэн нэртэй сэтгүүл гарсан.

2. Монгол дахь боловсролын социологийн судалгаа

1991 онд МУИС-д Социологийн тэнхим байгуулагдаж, үндэсний мэргэжилтэн бэлтгэж эхэлснээр мэргэжлийн салбар социологиуд заагдаж эхэлсэн.

Манай тэнхимийн үүсгэн байгуулагч социологийн ухааны доктор В.Отгоннасан багш “Боловсролын социологи” хичээлийг орж эхэлснээр Монгол дахь энэ салбар социологийн хөгжлийн эхлэл тавигдсан.

Боловсролын социологийн чиглэлээр “Оюутан хамт олны гишүүдийн нийтлэг хийгээд тухайлсан харилцааны асуудал” сэдвээр философич Хавх.Н (1984) судалгааны ажил бичиж дэд докторын зэрэг хамгаалсан.

1990-ээд оноос хойш боловсролын социологийн чиглэлээр хэд хэдэн судалгааны бүтээлүүд туурвигдаж, боловсролын салбарын олон асуудлыг социологийн шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс тусгайлан судлаад байна.

- *Тухайлбал:*

Доктор Зоригт.Д (1996) “Монголын нийгэм дэх боловсролын тогтолцоо: түүний эмх журмын түвшин, цаашдын хандлага” бүтээлдээ ... улс орны эдийн засаг, нийгэм, улс төр, оюун санааны байдал тогтворгүй, шилжилтийн үеийн Монголын нийгмийн боловсролын тогтолцооны эмх журмын түвшин, цаашдын чиг хандлагыг социологийн шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс авч үзэж, "тогтолцоо", "эмх журам" гэсэн ойлголтуудыг тодотгон боловсролын бүтцэд илүү анхаарах шаардлагатайг харуулж, ялангуяа боловсролын тогтолцооны дотоод зөрчилд ихээхэн анхаарлаа хандуулжээ.

Доктор Хаш-Эрдэнэ.С (2003) “Система образования как объект управления в Монгольском обществе” бүтээлдээ ...нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны эрс өөрчлөлтийн нөхцөл дэх Монголын боловсролын тогтолцооны удирдлага, менежментийг боловсронгуй болгох, уламжлалт хандлагыг шинэ нөхцөл байдалтай харьцуулан, түүний дотор төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн удирдлага, менежментийн ялгаатай байдалд анализ хийжээ.

Доктор Баярцэцэг.Б (2003) “Багшийн сургалтын ажлыг социологийн аргаар үнэлэх арга зүй” сэдвийн хүрээнд багшийн сургалтын үйл ажиллагааг бодитойгоор үнэлэхэд социологийн судалгааг хэрхэн ашиглах талаар өөрийн арга зүйг боловсруулж, үнэлгээний хуваариудыг гарган багш, суралцагчийн түвшинд туршилт судалгаа хийжээ.

Доктор Сарантуяа.О (2004) “Шилжилтийн үеийн боловсролын нийгмийн зарим асуудал” сэдвээр социологийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд тэрээр ... шилжилтийн үеийн боловсролын салбарт тулгарч буй зарим асуудлыг хөндөн судалсны зэрэгцээ өсвөр үеийнхний сурах идэвх сонирхол, сургууль завсардалт, багш суралцагчийн харилцааг тодорхой судалгаанд тулгуурлан задлан шинжилжээ.

Доктор Маш-Ариун.Б (2006) АНУ-ын Purdue-гийн их сургуульд “Монголын төрийн өмчийн их, дээд сургуулиудын шийдвэр гаргах үйл явц ба багш нарын ажлын сэтгэл ханамж” сэдвээр социологийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд тэрээр...төрийн өмчийн таван их, дээд сургуулийн удирдлагын шийдвэр гаргахад багш нарын оролцооны түвшинг тэдний ажлын сэтгэл ханамжийн байдалтай холбон судалж Монголын их, дээд сургуулийн багш нар шийдвэр гаргах үйл явцад хангалтгүй оролцож байна....тэдний ажлын сэтгэл ханамж дунд зэрэг байна...шийдвэр гаргах үйл явцад оролцож чадахгүй байгаа нь тэдний сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлтүүдийг тус тус хийжээ. Эдгээр бүтээлүүд нь боловсролын социологийн ерөнхий хийгээд тухайлсан асуудлуудыг өөрсдийн арга зүйгээр судалж, боловсролын социологийн цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

3.Боловсролын социологийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага

Сүүлийн 25 жилийн хугацаанд боловсролын социологийг сонирхох нь нийгмийн шинжлэх ухааны судалгаанд асар их нэмэгдсэнээс гадна боловсролын социологийн сэдвүүдийг хөндсөн судалгааны төсөл, нийтлэлүүдийн ихээр гарч, боловсролын социологийн судалгааны асуудалд төвлөрдөг бие даасан судалгааны хүрээлэнгүүд байгуулагдаж, профессорын зэрэглэлүүд бий болсон (Becker , 2017).

Энэ нь 19-р зууны сүүлч, 20-р зууны эхэн үед социологи бие даасан шинжлэх ухаан болон эрчимтэй хөгжсөн нь өрнөдийн нийгэм дэх олон нийтийн боловсролын тогтолцоо, түүнийг институтчлэхтэй давхцсан учраас боловсролын социологийн судалгаа хэрэгцээ шаардлага өндөр байсан (Karabel and Halsey 1977; Arum and Beattie 2000).

Боловсролын социологийн хөгжлийн орчин үеийн чиг хандлагад гурван үндсэн сорилт байна. Үүнд:

1. Соён гэгээрэл (нийгмийн бодит нөхцөл байдлыг социологийн тодорхойлолт, нарийн шинжилгээгээр шинжлэх ухааны үүднээс тодруулах)

Боловсролын социологийн гэгээрлийн үүрэг нь нийгмийн нөхцөл байдлын талаархи мэдлэгийг хүргэх, нийгмийн бүтцийг өөрчлөх, нийгмийн хөгжилд боловсролын үүргийг онцлон тэмдэглэхээр илэрнэ.

2. Социологийн мэдлэгийг түгээх (онол, загваруудыг системчлэх, нийгмийн баримтад социологийн тайлбар хийх)

Боловсролын социологийн хувьд бид боловсролын асуудлыг голчлон сонирхдог, өөрөөр хэлбэл эдгээр үзэгдлийн шалтгааны талаархи асуултанд социологийн сонирхолтой хариултыг өгөх явдал юм. Боловсрол чухал ач холбогдолтой хэдий ч боловсролын боломжийн тэгш бус байдал яагаад байсаар байна вэ, боловсролын ямар бодлого, хүчин зүйлүүд боловсролын боломжийн тэгш бус байдлыг бууруулах эсвэл нэмэгдүүлэхэд нөлөөлж байна вэ, гэр бүл, сургууль яагаад сурагчдын амжилт, сурлагын амжилтад нөлөөлдөг вэ зэрэг олон асуудлыг онол, нотолгоотой тайлбарлах шаардлага байна

3. Асуудлын шийдэл (социологийн таамаглал, нийгмийн технологи, бодлогын зөвлөгөө өгөх үүднээс хэрэглэх).

Боловсролын олон асуудлыг эмпирик судалгаа, онолын үүднээс шийдвэрлэх шаардлагатай учраас бодлогын оновчтой зөвлөгөө өгөх, нийгмийн технологийг хөгжүүлэх эсвэл урьдчилан таамаглах боломжийг олгохын тулд бидэнд шийдвэрлэх ёстой асуудлуудын бодит тодорхойлолт, үндэслэлтэй тайлбар хэрэгтэй (Hedström and Swedberg 1996).

Боловсролын социологийн зорилго нь боловсролын үйл явц, нийгмийн нөхцөл байдлыг системтэйгээр судлахаас гадна учир шалтгаан, арга механизмыг тодорхойлох замаар тэдгээрийг бүрэн тайлбарлах явдал юм. Эмпирик нотолгоог боловсролын бодлого эсвэл нийгмийн бодлогод оновчтой үндэслэл болгон ашиглаж болно. Тиймээс боловсролын социологийн цаашдын хөгжилд салбар дундын судалгааг хөгжүүлэх нь бас нэг гол сорилт болно. Боловсролын социологийн онол арга зүйн хувьд уламжлалт хандлагад функционализм, зөрчилдөөний онол давамгайлах шинжтэй байсан бол орчин үед постмодернизм, конструктивизм илүү голлох байр суурьтай болсон байна.

Боловсролын социологи нь боловсролын үүрэг, ач холбогдол, боловсролын агуулга, боловсролын тогтолцоо, боловсрол ба соёл гэсэн асуудалд илүү анхаарлаа хандуулан судалдаг байсан бол орчин үед нийгмийн эрэлт хэрэгцээ, мэргэжил сонголт, багшийн ур чадвар, ажлын сэтгэл ханамж, төгсөгчидийн ур чадвар, боловсролын тэгш бус байдал, боловсролын хувь хүний болон нийгмийн үр ашиг гэх зэрэг олон асуудлыг анхааран судлах боллоо.

Ном зүй

Сарантуяа О. (2005). *Шилжилтийн үеийн боловсролын нийгмийн асуудал*. УБ.

Майер А.А. (2012). Три вопроса для педагога. *Управление образования*.

Burton R.Clark. (1973). Development of the Sociology of Higher Education. *Sociology of Education*, Vol.46 pp 2-14.

Becker R. (2017). NMC Horizon Report: 2017 Higher Education Edition.

Arum Richard . (2000). The structure of Schooling: Reading in the Sociology of Education.

Bidwell Charles E . (1988). "Sociology of Educaation" in Neil Smelser (ed) Handbook of Sociology . pp 449-471.

Levinson, David L., Peter W. Cookson Jr and Alan R. Sadovnik (eds) (2002), Education and Sociology: An Encyclopedia, New York and London: Routledge Falmer.

Erikson, Robert and Jan O. Jonsson (1996), 'Explaining Class Inequality in Education: The Swedish Test Case', in Robert Erikson and Jan O. Jonsson (eds), Can Education Be Equalized?, Boulder, CO: Westview Press, pp. 1–63.

Rolf Becker (2017) Key challenges for the sociology of education: heoretical methodological, and empirical issues

Я.Отгонбаяр Их,дээд сургуулийн багшийн хөгжлийн социологийн шинжилгээ докторын диссертаци УБ.2014